

## КАИС СИСТЕМИЙН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛ

CAIS системийн хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж дууссан ба дараах голлох үр дүн гарна:

- Иргэн, хуулийн этгээд гаалийн мэдүүлгээ компьютер дээрээс цахимаар мэдүүлж, татвар хураамжаа цахимаар төлдөг болно. [WWW.GAALI.MN](http://WWW.GAALI.MN)
- CAIS системд тоон гарын үсэг нэвтэрнэ. Цахим мэдүүлэг баталгаажуулалтыг тоон гарын үсгээр баталгаажуулна.
- Гаалийн статистик мэдээлэл бодит цагийн горимоор гардаг болно.
- Гаалийн татвар, хураамж төлбөрийг олон хэрэгслээр банкны картаар онлайнаар, QR код уншуулж төлдөг болно.
- Гаалийн үндсэн үйл ажиллагааны автоматжуулалт, сайжруулалт хийгдэнэ.
- Төрийн болон бусад байгууллагатай мэдээлэлийг бодит цагийн горимоор солилцдог болно.
- Гаалийн талбайд ажиллаж байгаа хяналтын байцаагч хөдөлгөөнт орчинд таблет ашиглан ажиллах боломжтой болно
- Дэлхийн гаалийн байгууллагын сүүлийн үеийн дата модел 3.7 хувилбарт шилжинэ.

## КАИС СИСТЕМИЙГ ӨРГӨТГӨХ АЖЛЫН ХҮРЭЭНД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН 1-Р ХЭСЭГ

Тоног төхөөрөмжийн худалдан авалтын хүрээнд иж бүрэн компьютер – 745 ш, тусгай үзүүлэлт бүхий компьютер - 30 ш, цахим гарийн үсгийн токен - 1800 ш, сервер, firewall, switch – тус бүр 1 ширхэг нийлүүлсэн.

## КАИС СИСТЕМИЙГ ӨРГӨТГӨХ АЖЛЫН ХҮРЭЭНД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН 2-Р ХЭСЭГ

Тоног төхөөрөмжийн худалдан авалтын хүрээнд ГЕГ-ын Мэдээллийн технологийн төвийн сервер тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэнэ. Үүнд: Сервер, лиценз, сүлжээний тоног төхөөрөмж, хамгаалалтын програм, замчлагч төхөөрөмж, статистикийн систем, мэдээлэл солилцох систем, серверийн тог баригч, таблет компьютер багтана. ГЕГ-н сервер тоног төхөөрөмжийг шинэчлэснээр CAIS системийн 24 цагийн тасралтгүй, найдвартай ажиллах нөхцөл бүрдэхээс гадна гадны цахим халдлагаас хамгаалагдана. Дараагийн 10 жилд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлагагүй болно.

## ГАДААД ХУДАЛДААНЫ ЦАХИМ НЭГ ЦОНХНЫ МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Гадаад худалдаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжээс шаарддаг тусгай зөвшөөрөл, лиценз, мэдэгдэлийг цахим системээр олгодог болно. Ингэснээр гадаад худалдаанд оролцогчдод

тулгардаг хүндрэл бэрхшээлийг арилгаж, цаг хугацааг хэмнэнэ. Мөн төрийн байгууллагуудын үйл ажиллагаа сайжирч харилцан мэдээллээ солилцох боломжтой болно.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн (RIBS) төсөл, гаалийн автоматжуулсан мэдээллийн “КАИС, СЭПС” системийн өргөтгөл болон сервер тоног төхөөрөмжийн шинэчлэлийн ажлын хүрээнд гаалийн цахим үйлчилгээний ([www.gaali.mn](http://www.gaali.mn)) систем ашиглалтад оруулсан.

Уг систем нэвтэрснээр гаалийн байгууллагаас үзүүлж буй гаалийн бүрдүүлэлт, төлбөр тооцоо, лавлагаа, тодорхойлолт, гадаад худалдааны барааны статистик мэдээлэл, барааны ангилал, тарифын мэдээлэл болон тусгай зөвшөөрөл зэрэг нийт 30 гаруй үйлчилгээг иргэн, ААН-үүдэд цахимаар авах боломжийг бүрдүүлж байна. Тодруулбал:

- Иргэн, ААН өөрсдөө гаалийн мэдүүлгээ нөхөн бичиж, бичиг баримтын цахимаар илгээснээр ЦАГ ХУГАЦАА, ЗАРДАЛ хэмнэх;
- Экспорт/импортын мэдүүлгийн явцыг харах, ачаагаа хаана байгааг харах;
- Гаалийн татвар, хураамжийг шууд цахимаар төлөх;
- Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт, гаалийн зөрчлийн лавлагаа, гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагааг гаалийн байгууллагаас тусгай эрх авахгүйгээр цахимаар шууд авах;
- Гаалийн төв лабораторид магадлан шинжилгээ хийлгэх хүсэлт, гаалийн итгэмжлэл авах хүсэлт цахимаар илгээх;
- Гаалийн байгууллагаас олгож буй энгийн болон тусгай зөвшөөрлийн мэдээллийг авч, үйлчилгээг цахимаар авах;

Энэхүү гаалийн мэдээллийн автоматжуулсан системийн шинэчлэл нь Монгол Улс ДХБ-н худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, Гадаад худалдааны цахим нэг цонхыг бий болгох ажлын бэлтгэл болж байна.

Гаалийн байгууллагаас олгодог Гаалийн байгууллагад өртэй эсэх тодорхойлолт, Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагаа, Гаалийн зөрчлийн лавлагаа-г цахимаар олгож байна.

Гаалийн байгууллагад өртэй эсэх тодорхойлолт, Гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны лавлагааг өмнө нь СЭПС системээр олгож байсан бол Гаалийн зөрчлийн лавлагаа-г шинээр цахимжуулсан.